



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.08.20 № 37-1/86
танай _____-ны № _____-т

Асуудал зөвшилцөх тухай

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 17 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264003825

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 33 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛС
БОЛОН
АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК (АХБ)
ХООРОНДЫН
САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХӨТӨЛБӨР

ҮҮНЭЭС

(А) Ойрх Дорнодын мөргөлдөөн болон Орос-Украины дайны¹ улмаас үүссэн гадаад шокуудын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Монгол Улс хавсралт 1-д туссан хөтөлбөрүүдийг Азийн хөгжлийн банк /цаашид АХБ гэнэ/-ны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр санхүүжилт хүссэн болно.

(Б) Монгол Улс болон АХБ нь Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр ("Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр") байгуулах хүсэлтэй байгаа ба энэ хүрээнд Монгол Улс нь АХБ-ны зээлийн нөхцөлийн дагуу АХБ-аас зээлийн санхүүжилт хүсэж болно.

Иймээс талууд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 1.01. Доор дурдсан хэсэг 1.02 болон 1.03-т заасантай холбоотойгоор энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хавсралт 1-д заасан Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор АХБ нь Монгол Улсад зээлийн санхүүжилт олгож болно.

а) Зээлийн санхүүжилтийн хэмжээ нь дөрвөн зуун тавин сая (450,000,000) ам.доллараос хэтрэхгүй байх ба үүнийг АХБ-ны энгийн эх үүсвэрийн сангийн энгийн болон хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж болно.


Хэсэг 1.02. Хөгжлийн хөтөлбөр тус бүрийн санхүүжилтийн хэмжээг Монгол Улс, АХБ-тай харилцан тохиролцож байгуулах зээлийн болон санхүүжилтийн хэлэлцээрийн хүрээнд тохирно. Хөгжлийн хөтөлбөрүүдийн урьдчилсан жагсаалтыг хавсралт 1-д тусгасан болно.

Хэсэг 1.03 Хөгжлийн хөтөлбөр тус бүрийн зээлийн санхүүжилтийг Монгол Улсын хүсэлтийн дагуу болон АХБ-ны Захирлуудын зөвлөлөөр батлагдсаны үндсэн дээр АХБ-аас олгоно. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс нь зээл хүсэх, эсхүл АХБ нь зээл олгох үүрэг хүлээхгүй болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 2.01. АХБ-ны энгийн эх үүсвэрээс олгох энгийн зээлийн нөхцөл нь (а) 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох энгийн нөхцөлтэй зээлд хамаарах АХБ-ны Энгийн үйл ажиллагааны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

¹ АХБ-ны тодорхойлолтоор Оросын Холбооны Улсын Украин Улсад хийж буй дайн гэж тодорхойлно.



Хэсэг 2.02. АХБ-ны энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь (а) 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан АХБ-ны Энгийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлд хамаарах АХБ-ны Энгийн үйл ажиллагаа (хөнгөлөлттэй)-ны зээлийн журмын заалтууд, (б) АХБ-ны санхүүжилтийн бодлогууд, (в) холбогдох зээлийн хэлэлцээрүүдэд захирагдана.

Хэсэг 2.03. Монгол Улс нь АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөгжлийн төсөл, эсхүл хөтөлбөрийг АХБ-ны авлигын эсрэг арга хэмжээ, хамгаалал, жендер, худалдан авалт, зөвлөх үйлчилгээ болон зээлийн ашиглалтын бодлогууд, мөн холбогдох зээлийн хэлэлцээр болон бусад зээлийн баримт бичигт заасанд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэсэг 3.01. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг талуудын ил тод байдлын болон/эсхүл мэдээлэл тархаах бодлогын дагуу олон нийтэд ил тод болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэсэг 4.01. Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурал соёрхон баталснаар хүчин төгөлдөр болох ба 2029 он хүртэл эсхүл хавсралт 1-д туссан хөтөлбөр хэрэгжиж дуусах хүртэл аль сүүлд тохиох өдөр хүртэл хүчин төгөлдөр байна. Энэхүү хөтөлбөрийг талууд бичгээр тохиролцсоны дагуу сунгаж болно. Талуудын аль нэг тал нь Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг нөгөө талтайгаа зөвшилцсөний үндсэн дээр хүчингүй болгож болно.

- Заалтуудын төгсгөл -

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд тохиролцсон дээрх заалтуудыг энд хөрвүүлсэн болно.

Хөтөлбөрийг 202... оны ... дугаар сарын ...-ний өдөр Англи хэл дээр 2 хувь байгуулсан ба эх бичвэр бүр ижил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫГ төлөөлж

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКИЙГ төлөөлж

[_____]
Сангийн сайд

[_____]
Монгол Улсад суугаа Суурин төлөөлөгч

**Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН**

Гарын үсэг /Signature/ *У. Наран*

20*26* оны *8* сарын *13* өдөр
Улаанбаатар хот

**Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION**

Хөтөлбөрүүдийн жагсаалт

No.	Хөтөлбөрийн нэр	Нийт санхүүжилт (сая \$)
1	Төсөв, санхүү, эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөр (Дэд хөтөлбөр 2)	200.0
2	Болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт болон сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр	250.0*
	Нийт дүн	450.0

*Болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт болон сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд (i) анхны санхүүжилт нь 125 сая ам.доллар бөгөөд (ii) зээлийн шугамыг бүрэн ашиглаж нэмэлт санхүүжилт шаардлагатай болсон тохиолдолд дахин 125 сая ам.долларын нөхөн дүүргэлт хийх боломжтой.

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ *У.Майра*

2026 оны 8 сарын 13 өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

FINANCIAL FRAMEWORK ARRANGEMENT
BETWEEN
ASIAN DEVELOPMENT BANK (ADB)
AND
MONGOLIA

WHEREAS

(A) To respond to the adverse impacts of exogenous shocks, including those resulting from the Middle East conflict and Russia-Ukraine war¹, Mongolia may from time to time request ADB to provide lending to finance its development programs listed in Annex 1.

(B) Mongolia and ADB wish to establish a financial framework arrangement ("Framework Arrangement") within which Mongolia may request for lending from ADB to finance such development programs and the terms and conditions for ADB to provide such lending.

NOW THEREFORE the parties hereto agree as follows:

ARTICLE I

Section 1.01. Subject to the provisions set out in Sections 1.02 and 1.03 below, ADB may provide lending to Mongolia to finance its development programs as mentioned in Annex 1 to this Framework Arrangement.

a) The lending amount shall not exceed the equivalent of four hundred fifty million dollars (\$450,000,000), which may be used as regular and concessional loans from ADB's ordinary capital resources.

Section 1.02. The amount to finance each development program shall be as agreed upon in the signed loan agreement and/or facility agreement between ADB and Mongolia. The indicative details of the development programs are set out in Annex 1 hereto.

Section 1.03. For each development program, ADB shall provide lending only in response to a request by Mongolia and after approval by ADB's Board of Directors. This Framework Arrangement does not constitute an obligation on the part of Mongolia to request or on the part of ADB to approve any lending.

ARTICLE II

Section 2.01. The terms and conditions of ADB lending using regular loans from ordinary capital resources shall be governed by (a) the provisions of ADB's Ordinary Operations Loan Regulations Applicable to Regular Loans Made from ADB's Ordinary Capital Resources, dated 1 January 2022; (b) ADB's financing policies; and (c) the relevant loan agreement.

Section 2.02. The terms and conditions of ADB lending using concessional loans from ordinary capital resources shall be governed by (a) the provisions of ADB's Ordinary Operations (Concessional) Loan Regulations Applicable to Concessional Loans Made from ADB's Ordinary

¹ ADB refers to "Russia-Ukraine war" as "Russia's war in Ukraine".

Capital Resources, dated 1 January 2022; (b) ADB's financing policies; and (c) the relevant loan agreement.

Section 2.03. Mongolia shall implement the development program to be financed through ADB lending in accordance with all applicable ADB policies including those concerning anticorruption measures, safeguards, gender, procurement, consulting services, and disbursement to be described in detail in the relevant loan agreement and/or facility agreement and other loan documents.

ARTICLE III

Section 3.01 This Framework Arrangement may be publicly disclosed by each of the parties in accordance with their respective policies on disclosure and/or access to information.

ARTICLE IV

Section 4.01. This Framework Arrangement will come into effect on the date of ratification by the Parliament of Mongolia and will remain in effect until 2029, or the completion date of the programs listed in Annex 1, whichever is the later. It may be extended for a further period as may be decided in writing by the parties. Either party may terminate this Framework Arrangement in consultation with the other party.

--End of Clauses --

The foregoing record represents the understandings reached between Mongolia and Asian Development Bank upon the matters referred to therein.

Signed in duplicate in Ulaanbaatar, Mongolia, dated _____ each in the English language, all texts being equally authentic.

For
MONGOLIA

For
ASIAN DEVELOPMENT BANK

[]
Minister
Ministry of Finance

[]
Country Director
Mongolia Resident Mission

List of Indicative Programs

No.	Name of Program	Program cost (\$ million)
1	Strengthening Fiscal, Financial, and Economic Resilience Program (Subprogram 2)	200.0
2	Contingent Disaster Financing and Resilience Improvement Program	250.0*
	Total	450.0

* The amount indicated for the Contingent Disaster Financing and Resilience Improvement Program includes (i) an initial amount of \$125 million and (ii) a maximum of one potential replenishments each in an amount of up to \$125 million.

ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хоорондын
“Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийн талаар*

1. “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр” байгуулах шаардлага

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банк /цаашид “АХБ” гэх/-тай хамтран эдийн засгийн гадаад орчны сөрөг нөлөөлөл болон байгалийн гамшиг, эрүүл мэнд, эрчим хүч, хүнсний хангамжтай холбоотой онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай санхүүжилтийг шуурхай авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг байгуулахаар ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд 200.0 сая ам.доллартой тэнцэх төсвийн дэмжлэгийн зээл болон 250.0 сая ам.доллар хүртэлх эх үүсвэртэй Болзошгүй гамшгийн үеийн зээлийн шугамыг байгуулахаар АХБ-тай 2026 оны 08 дугаар сарын 13-ны өдөр хэлэлцээрийн төслийг эцэслээд байна.

Энэхүү хөтөлбөрийн гол ач холбогдол нь Засгийн газар дээрх санхүүжилтийг бүхэлд нь шууд авч ашиглах бус, харин эдийн засгийн гадаад шок, байгалийн гамшиг болон бусад онцгой нөхцөл байдал үүссэн үед урьдчилан тохирсон нөхцөлийн дагуу санхүүжилт авах боломжтой нөөц эх үүсвэрийг бүрдүүлэхэд оршино.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-г Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан. Үүний дагуу тус “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай.

2. “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн талаар

Засгийн газраас 2024 оны зудын гамшиг тохиолдсонтой холбоотойгоор АХБ-тай хамтран зуд, ган, үер, шороон шуурга, цасан шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдэл болон цар тахлын үед ашиглах боломжтой санхүүжилтийн хэрэгслийг ашиглах талаар санал солилцож эхэлсэн.

Энэ хүрээнд АХБ-тай хамтран 2025 оны 12 дугаар сараас эхлэн Монгол Улсад тохиолдож буй зуд, ган, үер, шороон шуурга, цасан шуурга, ой, хээрийн түймэр, газар хөдлөлт, цар тахал болон халдварт өвчний үед Засгийн газрын болон улсын хэмжээнд хариу арга хэмжээ авахад шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, тус санхүүжилтийг шийдвэрлэх чадамжийн талаар судалгаа хийж, Монгол Улсын гамшиг, эрсдэлийн санхүүжилтийн үнэлгээг боловсруулан 2026 оны 7 дугаар сард эцэслэж, Монгол Улсад гамшгийн үед шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээг тодорхойлох чиглэлээр хамтарч ажилласан.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-ийн Зорилт 2-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ 1-д “Байгалийн гамшиг, санхүүгийн хямрал зэрэг гэнэтийн нөхцөл байдал үүсэхэд ашиглах, мөн шаардлагатай бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор авч ашиглах боломжтой нөхцөлт санхүүжилтийн

бүтээгдэхүүн, бодлогод суурилсан зээл болон төсвийн дэмжлэгийн зээл зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас санал болгож байгаа хэрэгслүүдийг ашиглана” гэж заасны дагуу тус үнэлгээнд үндэслэн Монгол Улсын гамшгийн үеийн санхүүжилтийн хэмжээг тодорхойлох, тус санхүүжилтийн хэрэгцээг хангахад АХБ-аас зээлийн шугам үүсгэх боломжийг судалж, бэлтгэл ажлыг хангаад байна.

Цаашлаад Оросын Холбооны Улс, Украин Улс хоорондын болон Ойрх Дорнодын хурцадмал нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал нэмэгдэж, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөх, нийлүүлэлтийн сүлжээ тасалдах, тээвэр логиستيкийн зардал нэмэгдэх зэрэг эрсдэлүүд нэмэгдэж, дэлхийн улс орнуудын инфляцыг өсгөх, төсөв, төлбөрийн тэнцэл болон гадаад валютын нөөцөд ихээхэн дарамт үүсгэх эрсдэлтэй байна.

Ийнхүү олон улсын санхүүгийн зах зээлд тодорхойгүй нөхцөл бий болж гадаад санхүүжилтийн өртөг нэмэгдэж, хөрөнгө оруулалтын урсгал хумигдаж байгаа тул гадаад орчны сөрөг нөлөөллийг багасгах санхүүжилтийн нөөцийг бүрдүүлэх, хямд эх үүсвэрийг баталгаажуулахаар АХБ-тай “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг боловсруулаад байна.

2.1.Төсвийн дэмжлэгийн хөтөлбөр

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар албан даалгаварт “Гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, шаардлагатай зардлыг санхүүжүүлэх зорилгоор олон улсын байгууллага болон хөгжлийн түнш орнуудаас санал болгож буй төсвийн дэмжлэгийн зээл авах асуудлыг судалж, хэрэгжүүлэх” асуудлыг Сангийн сайдад даалгасны дагуу АХБ-аас төсвийн дэмжлэгийн зээл авах хэлэлцээрийг эхлүүлсэн.

Ойрх Дорнодын нөхцөл байдалтай холбоотойгоор Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн өсөлт 2026 онд 4.9%-тай тэнцэх буюу өмнө оны өсөлтөөс 0.6%-аар багасах төлөвтэй¹ байгаа бөгөөд энэхүү геополитикийн нөхцөл байдал үргэлжилсэн тохиолдолд хөгжиж буй орнуудын төсөв, төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд дарамт үүсэх эрсдэл өндөр болсон.

Монгол Улсын хувьд мөн адил хүнс, шатахууны үнэ өсөж, 2025 оны 11 дүгээр сараас хойш буурч байсан инфляц 2026 оны 2 дугаар сараас эхлэн нэмэгдэж 13 хувьд хүрсэн ба 2026 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн тэнцвэржүүлсэн орлого 14.6 их наяд төгрөг, нийт зарлага 16.8 их наяд төгрөг, төсвийн алдагдал 2.1 их наяд төгрөг байна.

Иймд Засгийн газраас төлбөрийн тэнцэл болон гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулах, төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор АХБ-аас 100.0 сая ам.долларын төсвийн дэмжлэгийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөж байсныг хэлэлцээрийн үр дүнд 200.0 сая ам.доллар болгон нэмэгдүүлээд байна.

¹ <https://www.adb.org/sites/default/files/publication/1155601/asian-development-outlook-july-2026.pdf>

Энэхүү зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 15 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил байх ба хүүгийн түвшний хувьд хөвөгч суурь хүү болох Баталгаат овернайт санхүүжилтийн хүү² дээр 0.5 хувийн нэмэгдэлтэй, хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл 0.15 хувь байна.

Энэхүү санхүүжилт нь Засгийн газрын богино хугацааны санхүүжилтийн дарамтыг бууруулж, гадаад эдийн засгийн сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх санхүүгийн эх үүсвэр болох ач холбогдолтой.

2.2.Болзошгүй гамшгийн үеийн зээлийн шугам

АХБ-тай хамтран боловсруулсан Монгол Улсын гамшиг, эрсдэлийн санхүүжилтийн үнэлгээний хүрээнд зудын гамшигтай жилүүдэд малын хорогдол ДНБ-ий 2-3%-тай тэнцэх хэмжээнд байгаа бөгөөд жилийн дундаж алдагдал нь тохируулсан тогтмол үнийн үндсэн дээр тооцоход 247 тэрбум төгрөг (67 сая ам.доллар) байсан бол одоогийн сүргийн хэмжээнд тохируулбал 362 тэрбум төгрөг (101 сая ам.доллар) болж өссөн. Зудын гамшиг хүндэрсэн тохиолдолд буюу 20 жилд 1 удаа тохиолдох зудтай жилд 814-2,855 тэрбум төгрөгийн (226-793 сая ам.доллар) шууд алдагдал, харин онц байдалтай жилд 2,671-3,686 тэрбум төгрөгийн (742-1,024 сая ам.доллар) шууд алдагдал амсахаар байгааг дүгнэсэн байна.

Харин газар хөдлөлт болон үерийн улмаас үүсэх эрсдэл нь боломжит эрсдэлийн үзүүлэлтүүдийн дагуу бага бөгөөд жилд дунджаар 88.6 тэрбум төгрөгийн (24.6 сая ам.долларын) алдагдал хүлээж байна.

Энэхүү гурван гамшгийн түүхэн дундаж жилийн алдагдал нь 331.0 тэрбум төгрөг (91.9 сая ам.доллар) байгаа бөгөөд Засгийн газраас жил бүр тохиолдох гамшиг эрсдэлийн үед санхүүжилтийн хэрэгцээг Засгийн газрын тусгай сангуудаас санхүүжүүлэх чадамжтай гэж дүгнэсэн боловч тухайн сангуудын хөрөнгийг жил бүр бүрэн ашиглаж, нөөц үүсгэхгүй байгаагаас томоохон гамшгийн үед жил бүр хуваарилагддаг Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэр хангалтгүй байна.

Иймд Засгийн газраас АХБ-тай байгалийн аюулт үзэгдэл, эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал болон эрчим хүч, хүнсний хангамжтай холбоотой онцгой нөхцөл байдлын үед хариу арга хэмжээ авахад зарцуулах 250.0 сая ам.доллар хүртэлх санхүүжилтийн эх үүсвэртэй Болзошгүй гамшгийн үеийн зээлийн шугамыг байгуулахаар төлөвлөж, холбогдох бэлтгэл ажлыг хангаад байна.

Уг зээлийн шугам нь ердийн зээлээс ялгаатай бөгөөд зээлийн шугамыг байгуулснаар зээлийн эх үүсвэрийг шууд авч ашиглахгүй, зөвхөн урьдчилан тохирсон онцгой нөхцөл байдал үүсэж, шаардлага хангасан тохиолдолд анхны санхүүжилт болох 125.0 сая ам.долларыг татан ашиглах боломжтой. Харин зээлийн шугамын хүчинтэй хугацаанд анхны санхүүжилтийг бүрэн ашиглаж, дахин санхүүжилт шаардлагатай болсон тохиолдолд 125.0 сая ам.доллараар нөхөн дүүргэлт хийх боломжтой бөгөөд энэхүү санхүүжилтийг мөн адил урьдчилан тохирсон онцгой нөхцөл байдалд ашиглах боломжтой. Зээлийн шугам болон нөхөн дүүргэлтийг ашиглах боломжтой хугацаа нь 3-5 жил байна.

² Secured-overnight financing rate /SOFR/

Өөрөөр хэлбэл, энэхүү хэрэгсэл нь гамшиг, хямрал үүссэний дараа санхүүжилтийн эх үүсвэр шинээр хайхын оронд урьдчилан байгуулсан гэрээний дагуу хурдан хугацаанд эх үүсвэр татах боломжтой, санхүүгийн хамгаалалтын хэрэгсэл юм.

Энэхүү зээлийн эх үүсвэр нь холимог нөхцөлтэй бөгөөд **энгийн нөхцөлтэй зээлийн** эргэн төлөлтийн хугацаа нь 15 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил байх ба SOFR дээр 0.5 хувийн нэмэгдэлтэй хөвөгч хүүтэй бол **хөнгөлөлттэй зээлийн** эргэн төлөлтийн хугацаа нь 25 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 5 жил, 2 хувийн тогтмол хүүтэй байна. Хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр нь тухайн үеийн Засгийн газрын боломжит хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс хуваарилагдана.

Тус шугамын хүрээнд дараах нөхцөл байдалд санхүүжилт татах боломжтой. Үүнд:

а. Үйл явдалд суурилсан санхүүжилт: Гишүүн орны Засгийн газраас АХБ-тай тохирсон байгалийн гамшигт үзэгдэл, эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал тохиолдсоноос гадна эрчим хүч, хүнсний аюулгүй байдалтай холбоотой онц буюу бэлэн байдал үүссэн тухай үндэсний болон орон нутгийн түвшинд зарлаж, АХБ-нд шаардлагатай баримт бичгийг хүргүүлснээр зээлийн шугамыг ашиглах боломжтой болно.

Тухайн орны онцлогоос шалтгаалан онц байдал зарлах боломжгүй эсхүл практик байхгүй тохиолдолд эрчим хүч, хүнсний аюулгүй байдалтай холбоотой доголдол, стратегийн нөөцийн хомсдол, үнэ огцом өсөх зэрэг нөхцөл байдлыг үндэслэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэн санхүүжилт олгоно.

б. Үр дүнд суурилсан санхүүжилт: Хөгжиж буй гишүүн орнуудын эрчим хүч болон хүнсний хангамжтай холбоотой гадаад цочролоос үүдэн үүссэн макро эдийн засгийн нөлөөллийг тодорхойлох зорилгоор АХБ-аас үр дүнд суурилсан доорх босго үзүүлэлтүүдийг тус зээлийн шугамд шинээр нэвтрүүлж байна. Үүнд:

i. **Түлш болон хүнсний импорт:** түлш болон хүнсний бүтээгдэхүүний жилийн импортын зардал өмнөх онтой харьцуулахад ДНБ-ий дор хаяж 1.5 хувиар нэмэгдсэн байх;

ii. **Гадаад төлбөрийн тэнцэл:** урсгал дансны тэнцэл өмнөх онтой харьцуулахад ДНБ-ий дор хаяж 1.5 нэгж хувиар буурсан байх;

iii. **Хэрэглээний үнэд үзүүлэх шилжих нөлөө:** эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой хэрэглээний үнийн индекс сүүлийн 5 жилийн дунджаас 3 нэгж хувиар давсан байх.

Дээр дурдсан үр нөлөө үүссэн тохиолдолд тухайн хөгжиж буй гишүүн орнууд нь тухайн нөхцөл байдал үүссэн өдрөөс хойш 90 хоногийн дотор зээлийн шугамыг ашиглах хүсэлтийг АХБ-нд хүргүүлнэ.

3.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т зааснаар Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан. Мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар Засгийн газрын өрийн хязгаарыг 2026 онд ДНБ-ий 50 хувь, 2027 онд 45 хувь, 2028 онд 45 хувь байхаар баталсан.

Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд төсвийн дэмжлэгийн зээл болон Болзошгүй гамшгийн үеийн зээлийн шугамыг бүрэн авч ашигласнаар Засгийн газрын өрийн хэмжээ 2026 онд ДНБ-ий 44.5 хувь байх төсөөлөлтэй байгаа бөгөөд дунд хугацаанд тус зээлүүд нь ДНБ-ий 1.6 хувиар Засгийн газрын өрд нөлөөлөхөөр байна.

Ингэснээр дунд хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарыг хангахаар байна.

Түүнчлэн, нөхцөл зээлийн шугамын хувьд зээлийн шугам байгуулсан хэмжээгээр Засгийн газрын өр шууд нэмэгдэхгүй бөгөөд зээлийн ашиглах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бодитоор татан ашигласан санхүүжилтийн хэмжээгээр өрийн үлдэгдэлд тооцогдох юм. Мөн дээрх санхүүжилтийн хэрэгслүүд нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-т заасан зорилттой бүрэн нийцэж байгаа болно.

---oOo---

ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

Монгол Улс болон Азийн Хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх 200.0 сая ам.долларын төсвийн дэмжлэгийн зээлийн эх үүсвэрийг Азийн хөгжлийн банкнаас дараах нөхцөлөөр санал болгож байна. Үүнд:

Зээлийн хүү: Баталгаат овернайт санхүүжилтийн хүү ¹ дээр 0.5 хувийн нэмэгдэлтэй,

Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл: 0.15 хувь,

Эргэн төлөх хугацаа: 15 жилийн хугацаатай, үүнээс эхний 3 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй болно.

Хүснэгт 1. Эргэн төлөлтийн хуваарь

Жил	Хагас жил	Зээлийн үлдэгдэл	Ашиглалт	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
2026	1		200,000,000.00		
2027	2	200,000,000.00			4,921,000.00
	3	200,000,000.00			4,921,000.00
2028	4	200,000,000.00			4,921,000.00
	5	200,000,000.00			4,921,000.00
2029	6	200,000,000.00			4,921,000.00
	7	200,000,000.00		8,333,333.33	4,921,000.00
2030	8	191,666,666.67		8,333,333.33	4,715,958.33
	9	183,333,333.33		8,333,333.33	4,510,916.67
2031	10	175,000,000.00		8,333,333.33	4,305,875.00
	11	166,666,666.67		8,333,333.33	4,100,833.33
2032	12	158,333,333.33		8,333,333.33	3,895,791.67
	13	150,000,000.00		8,333,333.33	3,690,750.00
2033	14	141,666,666.67		8,333,333.33	3,485,708.33
	15	133,333,333.33		8,333,333.33	3,280,666.67
2034	16	125,000,000.00		8,333,333.33	3,075,625.00
	17	116,666,666.67		8,333,333.33	2,870,583.33
2035	18	108,333,333.33		8,333,333.33	2,665,541.67
	19	100,000,000.00		8,333,333.33	2,460,500.00
2036	20	91,666,666.67		8,333,333.33	2,255,458.33
	21	83,333,333.33		8,333,333.33	2,050,416.67
2037	22	75,000,000.00		8,333,333.33	1,845,375.00
	23	66,666,666.67		8,333,333.33	1,640,333.33
2038	24	58,333,333.33		8,333,333.33	1,435,291.67

¹ Secured-overnight financing rate /SOFR/

	25	50,000,000.00		8,333,333.33	1,230,250.00
2039	26	41,666,666.67		8,333,333.33	1,025,208.33
	27	33,333,333.33		8,333,333.33	820,166.67
2040	28	25,000,000.00		8,333,333.33	615,125.00
	29	16,666,666.67		8,333,333.33	410,083.33
2041	30	8,333,333.33		8,333,333.33	205,041.67
НИЙТ			200,000,000.00	200,000,000.00	86,117,500.00

• Зээлийн хүүгийн төлбөрийг ашигласан зээлийн дүнгээс тооцож төлөх бөгөөд 200.0 сая ам.долларын эх үүсвэрийг 2026 онд ашиглахаар төлөвлөсөн тул 0.15 хувийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл төлөхөөргүй байна. **Харин зээлийн хүүгийн төлбөрт жилийн 9.8 сая ам.долларыг төлбөрийг төлнө.** Хэлэлцээрийн хүрээнд нийт 86.1 сая ам.долларыг хүүгийн төлбөрт төлөхөөр байна.

• Зээлийн эх үүсвэрийг Баталгаат овернайт санхүүжилтийн хүү буюу хөвөгч хүүтэйгээр авч ашиглаж байгаа тул хөвөгч хүүгийн төсөөлөл өөрчлөгдсөн тохиолдолд зээлийн хүүд төлөх төлбөр мөн адил өөрчлөгдөнө.

---oOo---

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКТАЙ “САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ
ХӨТӨЛБӨР”-ИЙГ БАЙГУУЛЖ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ
ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

1.Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

1.1.Дэлхийн эдийн засгийн төлөв байдал

Оросын Холбооны Улс, Украин Улс хоорондын болон Ойрх Дорнодын хурцадмал нөхцөл байдал нь эрчим хүчний зах зээлийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, газрын тос, байгалийн хийн үнийн өсөлт нь эрчим хүч импортлогч орнуудын үйлдвэрлэл, тээврийн зардлыг нэмэгдүүлэн инфляцын бууралтыг удаашруулж байна. Үүний зэрэгцээ худалдааны бодлогын тодорхой бус байдал, тарифын арга хэмжээ болон нийлүүлэлтийн сүлжээний өөрчлөлт нь дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын идэвхжилд сөргөөр нөлөөлөхөөр байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан Дэлхийн банк болон Олон улсын валютын сан¹ 2026 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллөө өмнө төсөөлснөөс 0.1 нэгж хувиар бууруулсан бол Азийн хөгжлийн банкнаас Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнө төсөөлснөөс 0.6%-аар бууруулсан².

Эрчим хүч импортлогч орнуудад түлш, тээвэр болон үйлдвэрлэлийн зардлын өсөлт бусад бараа, үйлчилгээний үнэд дамжин нөлөөлөх эрсдэлтэй байна. Улмаар инфляц зорилтот түвшинд хүрэх хугацаа удааширч, бодлогын хүү өндөр түвшинд удаан хадгалагдах нь хэрэглээ, хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн нөхцөлд дарамт учруулахаар байна.

Геополитикийн мөргөлдөөн цаашид хурцдах, эрчим хүчний нийлүүлэлт тасалдах, худалдааны хязгаарлалт нэмэгдэх, инфляц дахин эрчимжих болон санхүүгийн зах зээлд огцом хэлбэлзэл үүсэх, төсөв, төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөцөд дарамт үүсэх эрсдэл өндөр байна.

1.2.Монгол Улсын макро эдийн засгийн төлөв байдал

Улсын жилийн инфляц 2026 оны 7 дугаар сард 13.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.4 нэгж хувиар өслөө. Инфляцын өсөлтөд дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт голлон нөлөөлж, нийт инфляцын 9.6 нэгж хувийг бүрдүүлэв.

Жилийн дундаж инфляц 2026 онд Төв банкны зорилтот түвшнээс дээгүүр байх төлөвтэй байна. Оны эхний хагаст дотоодын хүнс, тэр дундаа махны үнийн өсөлт эрчимжсэн нь инфляцыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болов. Харин оны сүүлийн хагаст хүнсний нийлүүлэлт нэмэгдсэнээр үнийн өсөлтийн эрч саарах хүлээлттэй байна. Валютын ханшийн харьцангуй тогтвортой байдал нь импортын инфляцын дарамтыг сулруулж байна. Гэсэн хэдий ч олон улсын геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор шатахууны нийлүүлэлт тасалдах эрсдэл хадгалагдаж, үнэ тогтворгүй байгаа нь инфляцын цаашдын төлөвт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

¹ <https://www.imf.org/-/media/files/publications/weo/2026/update/july/english/text.pdf>

² <https://www.adb.org/sites/default/files/publication/1155601/asian-development-outlook-july-2026.pdf>

1.3.Монгол Улсын гамшгийн эрсдэл

Монгол Улс зуд, ган, голын болон уруйн үер, шороон болон цасан шуурга, ой, хээрийн түймэр, газар хөдлөлт зэрэг олон төрлийн байгалийн аюулт үзэгдэлд өртдөг бөгөөд температурын өсөлтийн улмаас цаг агаарын эрс тэс үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдсээр байна. Монгол орны газрын гадаргын жилийн дундаж температур 1940—2022 оны хооронд 2.46°C-ээр³ нэмэгдсэн бөгөөд 1988 оноос хойш дулаарал эрчимжжээ.

Азийн хөгжлийн банктай хамтран боловсруулсан Монгол Улсын гамшиг, эрсдэлийн санхүүжилтийн үнэлгээний хүрээнд зудын гамшигтай жилүүдэд малын хорогдол ДНБ-ий 2-3%-тай тэнцэх хэмжээнд байгаа бөгөөд жилийн дундаж алдагдал нь тохируулсан тогтмол үнийн үндсэн дээр тооцоход 247 тэрбум төгрөг (67 сая ам.доллар) байсан бол одоогийн сүргийн хэмжээнд тохируулбал 362 тэрбум төгрөг (101 сая ам.доллар) болж өссөн. Зудын гамшиг хүндэрсэн тохиолдолд буюу 20 жилд 1 удаа тохиолдох зудтай жилд 814-2,855 тэрбум төгрөгийн (226-793 сая ам.доллар) шууд алдагдал, харин онц байдалтай жилд 2,671-3,686 тэрбум төгрөгийн (742-1,024 сая ам.доллар) шууд алдагдал амсахаар байгааг дүгнэсэн байна.

Харин газар хөдлөлт болон үерийн улмаас үүсэх эрсдэл нь боломжит эрсдэлийн үзүүлэлтүүдийн дагуу бага бөгөөд жилд дунджаар 88.6 тэрбум төгрөгийн (24.6 сая ам.долларын) алдагдал хүлээж байна.

Энэхүү гурван гамшгийн түүхэн дундаж жилийн алдагдал нь 331.0 тэрбум төгрөг (91.9 сая ам.доллар) байгаа бөгөөд томоохон гамшгийн үед жил бүр хуваарилагддаг эх үүсвэрүүд хангалтгүй байна.

Монгол Улсад тохиолдож буй байгалийн гамшгийн эрсдэл, дэлхийн нийт сургамж авсан КОВИД-19 цар тахлаас гадна одоо өрнөж буй Оросын Холбооны Улс, Украин Улс хоорондын болон Ойрх Дорнодын нөхцөл байдлаас үүссэн эрчим хүчний нийлүүлэлт болон хүнсний хангамжийн доголдол нь дэлхийн эдийн засагт байгалийн гамшиг болон цар тахлын хэмжээнд нөлөөлөх эрсдэлтэйг Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагууд хүлээн зөвшөөрч өөрсдийн баримталж буй чиглэл болон геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас үүссэн гадаад орчны нөлөөг сааруулахаар зээлдэгч орнуудад санал болгож буй өрийн хэрэгслүүддээ бодлогын өөрчлөлт оруулж байна.

2.Салбарын болон эдийн засгийн үр ашиг

2.1.Төсөв, санхүү, эдийн засгийг бэхжүүлэх төсвийн дэмжлэгийн зээлийн хөтөлбөр (Дэд хөтөлбөр 2)

Дэлхийн эдийн засаг, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн гарах гадаад орчны үр нөлөөг багасгах, урьдчилан сэргийлэх зорилгоор гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх шаардлага үүсээд байгаа бөгөөд Олон улсын валютын сангийн дүрмийн 4-р заалтын хүрээнд хийсэн Монгол Улсын эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл

³ <https://unfccc.int/sites/default/files/resource/MONGOLIA%20FOURTH%20NC%202024.pdf>

байдлын тайланд мөн адил Монгол Улсын зүгээс “Валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцийг нэмж хуримтлуулах нь гадаад шокийн эрсдэл даах чадварыг бэхжүүлнэ”⁴ гэж зөвлөсний дагуу олон улсын байгууллага болон хөгжлийн түнш орнуудаас санал болгож буй төсвийн дэмжлэгийн зээл авах асуудлыг судалж, Азийн хөгжлийн банкнаас төсвийн дэмжлэгийн зээл авахаар тохиролцоод байна.

Энэхүү санхүүжилт нь Засгийн газрын богино хугацааны санхүүжилтийн дарамтыг бууруулж, гадаад эдийн засгийн сөрөг нөлөөллийг зөөлрүүлэх, Засгийн газраас төлбөрийн тэнцэл болон гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулах, төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх санхүүгийн эх үүсвэр болох ач холбогдолтой.

2.2.Болзошгүй гамшгийн үеийн санхүүжилт болон сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр

Монгол Улсад тохиолдох гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж, геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй гадаад орчны нөлөөлөл, эрчим хүчний нийлүүлэлтийн сүлжээ болон хүнсний хангамжийн доголдлоос шалтгаалсан томоохон сөрөг нөлөөг сааруулах, багасгах шаардлага үүсээд байна. Иймд энэхүү санхүүжилтийн эх үүсвэрийг баталгаажуулж, зээлийн шугамыг байгуулахаар Азийн хөгжлийн банктэй тохиролцоод байна.

Гамшиг тохиолдсон үед санхүүжилтийг татан ашиглахаас гадна доорх босго үзүүлэлтүүд хангагдсан тохиолдолд санхүүжилтийн эх үүсвэрийг шаардлагатай валютаар шууд татан ашиглах, тодруулбал зээлийн шугамын хүчинтэй хугацаанд анхны санхүүжилтийг бүрэн ашигласан бол нөхөн дүүргэх боломжтой санхүүгийн хэрэгсэл юм. Үүнд:

I. Түлш болон хүнсний импорт: түлш болон хүнсний бүтээгдэхүүний жилийн импортын зардал өмнөх онтой харьцуулахад ДНБ-ий дор хаяж 1.5 хувиар нэмэгдсэн байх;

II. Гадаад төлбөрийн тэнцэл: урсгал дансны тэнцэл өмнөх онтой харьцуулахад ДНБ-ий дор хаяж 1.5 нэгж хувиар буурсан байх;

III. Хэрэглээний үнэд үзүүлэх шилжих нөлөө: эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой хэрэглээний үнийн индекс сүүлийн 5 жилийн дунджаас 3 нэгж хувиар давсан байх.

Болзошгүй гамшгийн үеийн зээлийн шугам нь гамшиг, хямрал үүссэний дараа санхүүжилтийн эх үүсвэр шинээр хайхын оронд урьдчилан байгуулсан гэрээний дагуу хурдан хугацаанд эх үүсвэр татах боломжтой, санхүүгийн хамгаалалтын хэрэгсэл болох ач холбогдолтой.

---oOo---

⁴ <https://www.imf.org/-/media/files/news/press-release/2026/mcs062626-mng-mongolia-2026-concluding-statement-article-iv-consultation.pdf>